



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот


Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/836 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/60 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үнэлгээний хорооны гишүүн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн менежер Т.Батзаяа нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/182 дугаар тушаалаар гадаад сургалтын чөлөө авсан тул гишүүнийг тус газрын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэр хариуцсан мэргэжилтэн А.Эрдэнэмөнхийг болгон өөрчилсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (С.Цэдэнсодном)-т даалгасгай.

ДАРГА



Б.МӨНХБАТ